

### 3. ШАШИН СУДЛАЛ

Их номч Зава Дамдин гавжийн мэндэлсэний 140 жилийн ойд.

#### Зава Дамдин гавжийн намтар судлалаас үүдсэн бодлын хэлхээ

Доктор Ш. Сонинбаяр

##### 1. Унасан газар угаасан ус.

Зава Дамдин гавж Түшээт хан аймгийн Үйзэн гүний хошууны / Дайчин бэйсийн хошуу / Ахай сумын нутаг Дарцагтын эмээлийн Цагаан хадны бууцанд эцэг Шагдар, эх Содномпил нарын гэрт мэндэлжээ. Энэ газар нутаг бол одоогийн Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын нутаг юм. Машид гарсан хэмээгч XV жарны Гал туулай жилийн цагаан сарын шинийн гуравны өлзий учрал бүрдсэн сайн өдөр мэндэлсэн байна. Энэ нь нийтийн тооллын 1867 оны 2-р сарын 7-ны өдөр тохиожээ. Дайчин бэйсийн хошууны өвгөн ноён гэж хүндлэгдсэн Төрболд нь Манжийн төрийн эзэн Журганаас Үйзэн цолоор шагнагдаж байсан учраас хошуу ноёныхоо алдар нэрээр Говь - Үйзэн гүний хошуу гэж нэрлэгдэж байгаад Төрболд ноёны дараагаар хошуу ноён суусан Батсуурь ноёны үед Суурь дайчин бэйсийн хошуу гэж нэрлэгдэж байсан. Дайчин бэйсийн хошууны сүүлчийн ноён Мөнх – Очирын үед Зава Дамдин амьдарч байсан юм. [Зава Дамдин өөрийн төрсөн нутгийнхаа уул Дарцагтын сан тахилгыг Төвд хэлээр зохиож бичжээ. Зава Дамдины эцгийнх нь ах лам Лувсанжимба нь Цахиуртын жасын хурлын гэсгүй байв. Түүнийг цахиуртын гэсгүй болоход нэг шарга морь өгсөн аж. Энэ үед Орлой мэргэн хутагтын нутгаас бага насандаа эмэг эхээ дагаж Дайчин бэйсийн хошууны нутгат нүүдлэн суурьшсан Содномпил гэдэг бүсгүйн ээж охиноо төлөгч хүнээс асуухад шарга морьтой хүн гуйж ирвэл өгөөрэй гэсэн байна. Цахиуртын гэсгүй лам өөрийн дүү Шагдартаа хань болох бүсгүйг гуйснаар Шагдар Содномпил нар ханилан суусан ажээ. Зава Дамдингийн эх нь одоогийн Сүхбаатар аймгийн Уулбаян, Баяндэлгэр сумын гаралтай байна.]

##### 2. Шавийн эрдэм багшаас, Зулын гэрэл тосноос.

[Дайчин бэйсийн хошууны Хорины хамба лам гэж алдаршсан Лувсанбалдансанжаажав нь Зава Дамдиныг хүүхэд байхад нь сан тавьж угаасан бөгөөд Төвд цагаан толгойн үсэг заасан анхных нь багш юм.] Хорины хамба лам сүүлдээ Дайчин бэйсийн хошуу хамба ламаар өргөмжлөгдсөн байна. Энэ Лувсанбалдансанжаажав Төвдийн 12-р Далай лам Прэнлэйжамцын үед Төвдийн Балдан брайбүн хийдэд очиж, Буддын гүн ухаан судлаад Равжамба мяндаг хүртэж байв. Төвдийн Үй Зангийн олон нандин газруудад эргэл мөргөл хийж, Энэтхэгийн Доржданд хүрч Бурхан багшийн гэгээрлийн хутаг олсон газар Жадамбыг айлдсан гэж шавь нар нь ярьцгааж байсан. Хожим нь [Зава Дамдин гуай өөрийнхөө ачит багш Лувсанбалдансанжаажавын намтар солдивыг зохиосон юм. Лувсанбалдансанжаажав нь XX зууны эхэн үеийн Монголын номын мэргэдийн нэг болох Зава Дамдин, Говь – Түшээ гүний хошууны Найдан лам Цэнбэлдорж нарын номын багш байв. Лувсанбалдансанжаажав төвд хэлээр магтаал яруу найраг зэрэг нэг боть ном туурвижээ.]

##### 3. Тойн хуврага болсон нь:

[Зава Дамдин 7 насандаа өөрийн хошуу нутгийн Цахиуртын жаст сууж лам хуврага болжээ.] Цахиуртын жасын гэсгүй ах лам Лувсанжинбаар уншлага заалгуулсаны дээр ловон багш Лувсанбалдансанжаажаваар төвд хэл бичиг заалгуулж, Их Хүрээний уншлагын аймгийн номуудыг бүрэн цээжилсэн байна.] Анхлан шавилан сууж лам болсон хийд Цахиуртын жас нь Дайчин бэйсийн

хошууны Эрдэнэ – Ахай сумын нутагт Халх – Өөлдийн дайн самууны үед Өндөр Гэгээний ар гэр ахан дүүс хүрээ хийд нь Бага газрын чулууны орчим нүүж суурьшиж байсан түүхтэй. Тэр үед Өндөр Гэгээний авай ээж Цахиуртын жасыг үндэслэн байгуулсан юм. Мөн үүнтэй нэг үе Өндөр Гэгээний Далай ээж нь Далай ээжийн жасыг үндэслэн байгуулсан юм. Өндөр Гэгээний түүх намтартай салшгүй холбоотой Авай ээжийн жас, Далай ээжийн жас Дундговь аймгийн Дэлгэрцогт сум, Адаацаг сум, Төв аймгийн Баянбараат сумдын нутагт байна. Авай ээжийн жас буюу Цахиуртын жасын төвд нэр нь Дорждамба гэдэг байв. Зава Дамдин гуай анх лам болж хуралд хурсан газар гэж хожим хойноо Цахиуртын жас дээр олон дахин морилж байсан байна.

#### 4. Их Хүрээнд ном үзсэн нь:

Өөрийн багш Лувсанбалдансанжаажавын зөвлөсөний дагуу Их Хүрээний гүн ухааны ном судалдаг гол сургуулийн нэг болж байсан Гунгаачойлин дацанд шавилан суусан юм. Их Хүрээний Тойсамлингийн аймагт сууж Гунгаачойлин дацанд цанид чойрын гүн ухааны ном судлажээ. Их хүрээний хувилгааны аймгийн цорж Жигжидээр учир шалтгааны ухааны үндэс болсон Дүйрааг заалгасан байна. Их хүрээнд байхдаа гавж Лувсандаш, гавж Балдандорж нараар учир шалтгааны ухаан, билиг барамидын гүн ухааныг хөтлүүлэн заалгажээ. Амдо нарын аймгийн Агваанринчин, Эрхэмийн аймгийн аграмба Минжүүрдорж, Боржигин Жамц, Шаддүвдандар аграмба нарын зэрэг Их хүрээний алдартай номын мэргэдээр гүн ухааны номыг хөтлүүлэн заалгаж суралцсан байна. 1905 онд Их хүрээний Гунгаачойлин дацанд гавжийн дамжаа барьж гавж болсон байна. 1904 оны Луу жил 13-р Далай лам Түвдэнжамц Их хүрээнд морилоход бараалхаж номын авшиг хүртсэн юм. Гавж болсоны дараагаар Их хүрээний залуу лам нарт Буддын гүн ухааны номыг зааж сургаж байв. Их хүрээнд сууж байх үедээ Дарба бандидагийн хүрээ, Эрдэнэзуу, Чин сүжигт Номун хааны хүрээ, Туулын гүний хүрээ зэрэг орон хийдүүдээр морилж явсны зэрэгцээ Алагша яам, Утай, Гүмбүм хийдэд очиж эргэл мөргөл хийж байсан байна.

#### 5. Ном зохиол туурвисан нь:

Зава Дамдин гавж төвд хэлээр 17 боть ном зохиосон юм. Түүний зохиолуудын дотор учир шалтгааны ухаан, билиг барамидын гүн ухааны зохиолууд байна. Зава Дамдин гуай “Хорчойнжун” хэмээх түүхийн зохиолоо бичихийн өмнө бэлтгэл болгож хураангуйлсан “Номын лавай мишээсний дуун эгшиг” хэмээх үндэс зохиолоо туурвижээ. Энэхүү үндэс зохиолдоо тулгуурлан “Хорчойнжун” зохиолоо 1931 онд бичиж дуусгасан байна. Зава Дамдин гавж төвд хэлээр туурвисан зохиол номуудаа модон бараар хэвлүүлж байв. Түүний зохиолуудын дотроос “Хорчойнжун” гэж алдаршсан Монголын Бурханы Шашны түүхийн зохиол нь ихээхэн алдартай билээ. Энэхүү номыг гадаад дотоодын эрдэмтэн мэргэд сонирхон үздэг юм. Түүний зохиолуудын нэг болох “Их нигүүлсэхүйн магтаал” гэдэг номыг 14-р Далай багш үзэж болгоон таалж сайшааж байжээ. Зава Дамдин гуай таалал төгссөнөөс хойш түүний дотны шавь Жаал Шийрав гэдэг лам зохиол бүтээлийг хямгадан хадгалж байгаад өөрийн шавь Гончигдорж ламд залгуулж өгсөн юм. Гандан хийдийн шавь Гончигдорж гуай 1970 оны дундуур Гүрүдэваа ринбочид өгч хэвлүүлж өгөхийг хүссэн байна. Үүний дагуу Гүрүдэваа ринбочи Зава Дамдины зохиолыг 17 боть болгож, Энэтхэг улсад хэвлүүлсэн юм.

#### 6. Дэлгэрийн чойрыг байгуулсан нь:

Дайчин бэйсийн хошууны гол хийд болох Их жасын чойрын дацангийн лам нар салж нүүн Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын нутаг Хөшөөн тал, Сэнжит халтарын ууланд түр суурьшиж байсныг Зава Дамдин гавж 1918 онд Дэлгэрцогт уулын энгэрт газар сонгож нүүлгэн шинээр цогцлоон байгуулсан юм. Орон

нутагтаа Дэлгэрийн чойр гэж алдаршсан Дашчойжорлин хийдийг 8-р Богд Живзундамбад айлтгасанд Чойен Одсаллин гэдэг нэр хайрлаж мөрдөж явах жаяг зохиож өгсөн байдаг. Зава Дамдин гавжийн төрөлх нутагтаа үндэслэн байгуулсан Дэлгэрийн чойрын хийд 1937 он хүртэл 20 шахам жилийн дотор өргөжин тэлж Буддын гүн ухаан судладаг цанид чойрын дацан, тарнийн гүн ухааны онолыг судладаг жүд дацан, анагаах ухаан судлах манба дацан, зурхайн ухаан судладаг [зурхайн дацан] зэрэг олон эрдэм ухааны чиглэлээр сургалт явуулдаг дацангууд бүхий томоохон хийд болтлоо хөгжсөн байна. 1930 хэдэн оны байдлаар 500-аас 600-аад лам хурдаг Дайчин бэйсийн хошууныхаа шашин, ном соёлын гол төв болж өргөжсөн юм. Дэлгэрийн чойрыг байгуулж ялангуяа цанид чойрын гүн ухааны дацанг хөгжүүлэх үедээ өөрийн шавь анги Долгор, Авшаа гүний Ёндон зэрэг шалгарсан гэвш нарыг Их хүрээнээс дагуулан очиж чойрын дамжааг тогтоож өгсөн байна. Зава Дамдины Дэлгэрийн чойроос төрж гарсан олон лам нар хуврагуудын дотроос Шар чойжин гэж алдаршсан Чойжин гавж нь Их хүрээний Гунгаачойлин дацангийн сургуулиар сайтар суралцсан нэгэн байв. Чойжин гавж Дэлгэрийн чойр дээр суун залуу лам нарт Буддын гүн ухааныг сургадаг гол лам байв. Чойжин гавж нь Үйзэн Хориноор нутагтай одоогоор Дундговь аймгийн Сайнцагаан сумын харъяат байсан юм. Мөн Зава Дамдины дотны шавь Шийрав Их хүрээний Гунгаачойлин дацанд ном үзэж байгаад, Дэлгэрийн чойр дээр очиж Дэлгэрийн чойрын цорж лам байсан юм.

#### **7. Судар бичгийн хүрээлэнд ажилласан нь:**

Богд Хаант Монгол улсын үед Монголын түүх бичиг зохиох эрдэмтдийн дунд Зава Дамдин гавж уригдан ирж ажиллаж байв. 1921 онд үндэс суурь нь тавигдсан Судар бичгийн хүрээлэнд Зава Дамдин гавжийг урьж ажиллуулж байв. 1924 онд судар бичгийн хүрээлэнд сул гишүүнээр Зава Дамдинг сонгож байсан байна. Тэр үед Судар бичгийн хүрээлэнг толгойлж байсан Онходын Жамъяан гүн, Сэцэн ханы Бат-Очир бичээч, Сутай уулын Мишиг аругай нарын зэрэг эрдэмтэдтэй хамт ажиллаж байжээ. 1930-аад оны үед Судар бичгийн хүрээлэнд орчуулга, ном зохиол судлах ажил эрхлэж байсан гурван лам байжээ. Зава Дамдин гавжаас гадна Их хүрээний номтой гэвш гэгдэж байсан Хангал сумын Шагж гэвш, Сартуулын Гэлэгжамц дооромбо нар судар бичгийн хүрээлэнд ном орчуулах зэрэг ажил хийж байв. 1930-аад оны дундуур Оросын шинжлэх ухааны академийн 150 жилийн ойд Зава Дамдинг урьсан урилга илгээж байв. Энэ үед Зава Дамдин гавж бие чилээрхүү байсан учраас оронд нь өөр лам явуулж байсан байна. Судар бичгийн хүрээлэнд уригдаж ажиллаж байхдаа Тубянский, Цэвээн Жамсранов нарын эрдэмтэдтэй танилцан дотно харилцаатай байжээ. Ялангуяа Тубянский өөрийнхөө машинаар Дэлгэрийн чойр дээр очиж Зава Дамдин гавжтай уулзаж байв. Зава Дамдин гавжийг Дэлгэрийн чойр дээр сууж байхад түүнд бараа болж байсан Ишжамц лам багшийнхаа тухай олон сайхан дуртгал ярьсан байдгаас нэгийг дурдвал: Нэг удаа Зава Дамдин гавж өглөө эрт Ишжамцыг дуудаж миний хүү сайхан цай чанаарай холын хүн ирнэ гэж. Хэлсэн ёсоор цай чанаж бэлтгэж байтал Богдын хүрээнээс Хатанбаатар Магсаржав ирж уулзсан юм гэж Ишжамц гуай ярьж байжээ. Энэ бол зөн мэдлийн ухаан билиг нь их хөгжсөний гэрч гэж хэлж болох юм. 1924 онд Бүгд Найрамдах улс байгуулж Үндсэн хууль батлах үед Зава Дамдин гавжийг урилгаар оролцуулж байж. Монгол улсын төрийн сүлд далбааг хэлэлцэж батлахад Зава Дамдин гавжийн саналыг үндэслэж төрийн туг сүлдэнд Алтан соёмбо үсэг оруулсан юм гэдгийг надад Мянгадын гэвш Сандаг гуай хуучилж байсан юм.

#### **8. Гадаад, дотоодын эрдэмтэдтэй харилцаж байсан нь:**

Монгол улсын ерөнхий сайд байсан А. Амар гуайтай судар бичгийн хүрээлэнд байхдаа танилцаж, А. Амар гуай хүндэтгэн биширч шавь орсон байдаг. А. Амар

сайд Судар бичгийн хүрээлэнгийн дарга байхдаа өөрийнхөө жасааг Зава Дамдин зэрэг лам нараар уншуулдаг байсан тухай Дияанч багш дурсдаг байв. Оросын Монголч эрдэмтэн Б.Я. Владимирцов эрдэм шинжилгээ судалгааны ажлаар 1920-иод оны үед Хүрээнд ирж Цэвээн Жамсранов зэрэг Судар бичгийн хүрээлэнгийн эрдэмтэдтэй уулзах үед Зава Дамдин гавжтай танилцсан байна. Оросын дорно дахин судлаач гүн ухаантан Ф.И. Шербатскойтой Зава Дамдин гавж судар ном солилцдог өргөн харилцаатай байсан бөгөөд Шербатскойн шавь Тубянский судар бичгийн хүрээлэнд 1930-аад оны үед ажиллаж байхдаа Зава Дамдин гавжтай дотно харилцаа тогтоон, "Современная Монголия" сэтгүүлд Зава Дамдины түүхийн зохиолуудын талаар судалгааны өгүүлэл хэвлүүлсэн юм. 1920-иод оны үед Төвдөөс ирсэн Дарма Лочин лхарамбатай танилцаж ном эрдмийн харилцаатай байв. Дарма Лочин лхарамбыг Монгол руу явахад Дэxor Ганжуурваа Лувсанжамба гэдэг лам Монголын Да хүрээнд Лувсандаян гэдэг ламтай уулзахыг ихэд захисан юм. Энэ Дэxor Ганжуурваа Лувсанжамба лам 1900-аад оны эхээр Их Хүрээнд ирж Дэвүү Жорван гэж алдаршсан лхарамба Лувсанжамба юм. Хүрээнд байхдаа Зава Дамдин зэрэг олон эрдэмтэн лам нартай танилцсан байна. Дарма Лочин лхарамба Да Хүрээ, Ховдын Шар сүм, Улаангомьн хүрээ, Буриадын Түнхэн нутгаар залагдаж яваад 1924 онд Төвд рүүгээ буцжээ. Энэ үеийн төвдийн шалгарсан гэвш Бурхан багшийн айлдсан 108 боть Ганжуур цээжтэй дараагийн дүрийн хувилгаан Лочой ринбочи эдүгээ Энэтхэгт энх тунх амьдарч байна. Буриадын Агваан лхарамбатай ном эрдмийн нягт холбоотой байсан бөгөөд Зава Дамдины түүхийн зохиол "Хорчойнжун" номонд гарч байгаа зарим зүйлийг Агваан лхарамба тодруулж асуусан баримт байдаг юм. Буриадын Агваан Доржиев бага залуу насандаа Төвдийн Врайбүн хийдийн Гоман дацанд шашны гүх ухааныг судлаад лхарамба болжээ. Агваан лхарамба 13-р Далай лам Түвдэнжамцад цанид чойрын гүн ухаан сургаж заах багшаар томилогдон 13-р Далай ламын цаншив болж байв. Зава Дамдин Да хүрээний Дашчоймбэл дацангийн шалгарсан гэвш анги Шагдар гуайтай нас ойролцоон дээр ном эрдмийн бат зузаан холбоотой байв. Мөн 20-р зууны эхэн үеийн Монголын гүн ухаантан Дарба бандида Агваанчойнжурдондүвтой ном эрдмийн нөхөрлөл холбоо сайн байсны дээр Дарба бандида Агваанчойнжурдондүвийн заллагаар бандидын хүрээ Дашдаржайлин хийдийн дэргэдэх Булган уулын Найдодыг зохиож байсан байна. Энэ нь одоогийн Хөвсгөл аймгийн Рашаант сумын нутаг юм. Дайчин вангийн хошууны Вангийн хүрээний аграмба Шаддүвдандар, Чин сүжигт Номун ханы хүрээний бандида лам Түвдэнням зэрэг номын мэргэдтэй багш шавийн барилдлагатай байв. Зава Дамдин гавж Да хүрээнд сууж байхдаа хүрээний гавж, аграмба нарт дуун ухаан гэж алдаршсан эртний Энэтхэгийн санскрит хэлний зүй зааж байжээ.

#### 9. Таалал төгссөн нь:

[Зава Дамдин гавжийн бие лагшин 1936 оне үеэс чилээрхсэн юм.] Энэ үедээ Да Хүрээнд байсан Дайфу хэмээх Хятад эмнэлэгт биеэ үзүүлж сувилуулдаг байв. Нэг удаа Гандан хүрээнд Майдар эргэж байгааг дуулаад бараа бологч нартаа хэлж би энэ удаагийн Майдарт мөргөх ёстой юм шүү гэж. Их Хүрээний Майдар уламжлалаараа эргэж байх үед Зава Дамдин гавж тосон очиж, хадаг гарган дөхөж ойртоход Хүрээ Майдар түр зогсож, Зава Дамдин гуай Майдар бурханд мөргөж "Донба лана" уншин адис авсны дараа Майдар эргэж явсныг түүний шавь нар дурсан ярьцгаадаг. Мөн өөрийн дотны бараа бологч шавь нартаа ярихдаа: Сүнгийн анги лам бид хоёр Майдарын оронд төрөх ерөөлийг их тавьсан байсан даа, одоо ч би удахгүй явах цаг болсондоо гэж байв. Шадар бараа бологч нартаа гэрээслэн захисан нэг үг байдаг юм, Намайг өнгөрсний дараа миний цогцсыг миний байгуулсан хийд Дэлгэрийн чойрын баруухантаа байдаг Цамын-ус гэдэг газар тавьж хайлна биз дээ, би залуу цагтаа тэнд 4 хүнийг гэлэн болгосон юмсан гэж айлджээ. 1937 онд Гандангийн дэнжийн хойд талд байсан Жарүнхашорын сувраганы ойролцоо өөрийн шавь Авшаа гүний

Ёндон гуайн жижиг гэрт таалал төгсжээ. Дараа нь гэрээсэлсний ёсоор тэмээн тэргэнд шарилыг нь ачаад шавь нар нь авч явсан үед Дотоод яамнаас баривчлахаар ирсэн байдаг. Нутгийнх нь Дэлгэрийн чойрын лам нар Гонзог ерөөлийг хуран сэрэгчог үйлдэж, аг тарнийн зан үйлийн дагуу хайлсан юм. Харин шарилыг хайлах үед түүний зүрх нь хайлалгүй чулуужин үлдсэн байдаг. Энэ үед Зава Дамдингийн шарилыг хайлахад оролцож байсан Мятав гуай хожим 1990 оны эхээр ярьдаг байв. Зава Дамдин гуайг таалал төгссөний дараа түүний шавь нарын нэг болох Жаал Шийрав, мөн Гэнпил, Мятав, Ренчиндорж, Гончигдорж нарын зэрэг настан буурлууд багшийнхаа ном зохиолыг хямгадан хамгаалж хэлмэгдлийн хүнд хэцүү үед авч гарсан юм.

#### **10. Зава Дамдингийн байгуулсан Дэлгэрийн чойр дахин сэргэсэн нь:**

1990 оны эхээр хуучин Дэлгэрийн чойр дээр лам явсан хэсэг лам хуврагууд Чойрын суурин дээр хурлаа дахин сэргээн гаргасан юм. Энэ өвөгчүүлийн дотор уран Гэнпил, уран Мятав нар голлон хөөцөлдөж хурлаа сэргээсэн байдаг. Зава Дамдин гавжийн өргөө гэр, ном судар, бусад үнэт зүйлсийг Гэнпил уул хаданд нууж байснаа хуралдаа гаргаж тавьсан байна. 1990-ээд оны эхээр хөдөө орон нутагт хурал ном дахин сэргэх үед хамгийн анх Дэлгэрийн чойрт Майдар эргэсэн юм. Дэлгэрийн чойрын Майдарын хэрэгсэлийг төхөөрч бэлтгэсэн Мятав гуай хамба багшийнхаа гэрээслэлийг биелүүлсэн гэж ярьдаг байсан. Мятав гуайг 1930-аад оны үед залуу зандан насандаа Дэлгэрийн чойрын лам байхад нь Зава Дамдин гавж дуудан уулзаад, ирээдүйд Майдарын шашин дэлгэрэх учиртай юм, би энэ хийддээ Майдар эргэдэг болгохсон гэж хүсэж явдаг, чамайг гарын дүйтэй гэж мэдэх учраас Майдарын хэрэгсэлийг төхөөрч өгөхийг даалгаж хадаг, шар цоохор олбогийг барьж гавж болгоё гэж айлдсан юм байна. Үүний дараа 1936, 1937 оны үед шашны хэлмэгдүүлэлт эхэлж Мятав гуай ч нийтийн адил энгийн амьдралыг хөөжээ. Мятав гуай Дэлгэрийн чойроо дахин сэргэхэд багшийнхаа гэрээслэлийг санан дурсаж Майдар эргэдэг болгосон юм. Уран Гэнпил гуайг төрөөс 1990-ээд оны эхээр Алтан гадас одонгоор шагнаж байв. Энэ тухай Гэнпил гуай ярихдаа хамба багшийнхаа ач буянгаар энэ одон авч байна гэдэгсэн. Төр засгаас Гэнпил гуайг Зава Дамдингийн өв соёлыг хайрлан хамгаалж ирсэн гавъяаг нь үнэлж Алтан гадас одонгоор шагнасан байна. Одоо энэ буурлууд ертөнцийн мөнх бусыг үзүүлсэн. Одоо Зава Дамдин гуайн зарлиг номыг сонсож явсан настай хоёр, гуравхан хүний нэг нь Дэлгэрцогт сумын иргэн эдүгээ 90 гаран насыг зооглож яваа Дагвадорж гуай юм. Дагвадорж гуай залуу насандаа Дэлгэрийн чойр дээр Буддын гүн ухааны номыг судалж домын дамжаа барьсан гэвш хүн юм.

#### **11. Зава Дамдингийн зохиол бүтээлийн судалгаа:**

Монголын түүхийн сурвалж бичгүүдийн дотор нилээд алдартай түүхийн ном "Хорчойнжун" судрыг 1940, 1950-аад оны үед төвдөч Ишсамбуу, гавж Цэвэгийн Дорж нар монгол хэлнээ орчуулсан байна. Монгол улсын хөдөлмөрийн баатар академич Ш. Бира гуай Зава Дамдингийн "Хорчойнжун" судрыг шинжлэх ухааны үүднээс судалж, 1960-аад оны эхээр эрдмийн зэрэг хамгаалсан юм. Энэ бол монголын эрдэмтэдийн дотроос Зава Дамдингийн "Хорчойнжун" зохиолыг судалсан анхны хүн юм. Орос хэл дээр Зава Дамдингийн "Алтан дэвтэр" хэмээх номыг 1960 оны эхээр хэвлүүлжээ. 1990-ээд оны эхээр сэтгүүлч До. Чулуунбаатар Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын нутаг Дэлгэрийн чойрын суурин дээр очин Гэнпил гуайгаас ярилцлага авч монгол телевизээр нэвтрүүлж байсан. 1996 онд Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын уугуул М.Бум-Аюуш, Л.Мөнх-Очир, Н. Дариймаа, Адаацаг сумын уугуул Х. Нямбуу, Дорнодын Матад сумын Г. Аким нарын хамт мөхөс миний бие Зава Дамдин санг байгуулж, 1997 онд Дундговьт тэмдэглэсэн Зава Дамдингийн мэндлэсний 130 жилийн ойг хийлгэж байв. Энэ ойд зориулж миний бие Зава Дамдингийн намтарыг төвд

хэлнээс орчуулж гаргасан. Зава Дамдингийн мэндлэсний 140 жилийн ойг угтаж сэтгүүлч До.Цэнджав зохиолыг бичиж найруулагч Нагнайдорж, Бухаа, Б. Адъяа нар хамтран баримтат уран сайхны 2 бүлэг кино хийсэн юм. Монгол Улсын шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн доктор Л.Хүрэлбаатар Хятад улсын Ланжоу хотын баруун хойтын Үндэсний Их Сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүлийн 2006 оны нэгдүгээрт “Алтан дэвтэр ба Дээд Монголын Шашин соёл” хэмээх томоохон өгүүлэл нийтлүүлжээ. 1970-аад оны дундуур Энэтхэгийн профессор Локеш Чандра Зава Дамдингийн “Хорчойнжун” зохиолыг төвд эхийн хамт оршил бичиж хэвлүүлсэн байна.

#### **12. Зава Дамдингийн мэндлэсний 130 жилийн ой:**

Ой угтсан ажлын хүрээнд 1996 онд Зава Дамдингийн номын мөрөөр тойрон аялалыг Зава Дамдин сангаас зохион байгуулж, Дундговьор явсан. Зава Дамдин сангаас зохион байгуулж Их номч эрдэмтний ой болохтой холбогдож Улаанбаатар хотод хэвлэлийн бага хурал зохион байгуулсан. 1996 оны хавар Зава Дамдингийн мэндлэсний 130 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурал хийлгэсэн юм. Энэ хуралд ШУА-ийн удирдлагуудаас академич, доктор, профессор С. Норовсамбуу, Бүгд Найрамдах Энэтхэг улсаас тус улсад суугаа элчин сайд Бакула ринбочи, МУИС-ийн багш, төрийн шагналт С. Чоймаа, ШДС-ийн багш нар болон Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэмтэд оролцсон юм. Энэ хурлын илтгэлүүдийг Гандантэгчэнлин хийдийн сэтгүүл “Лавай эгшиг” – т гаргасан. 1997 оны 8 сарын эхээр Дундговь аймгийн төвд Зава Дамдингийн мэндлэсний 130 жилийн ойг өргөн дэлгэр тэмдэглэсэн юм. Энэ үед Дундговь аймгийн засаг дарга Ж.Хүүхэнбаатар байв. Их хурлын гишүүн Ж. Наранцацралт, Р. Гончигдорж, Хөдөлмөрийн баатар Хайдав гуай зэрэг төр, нийгэм, соёл, урлагийн зүтгэлтнүүд оролцсон юм. Дундговь аймгийн 15 сум наадмаа хийлгүй хүлээж байгаад Зава Дамдингийн ойд өргөн оролцож олон хурдан морьд ирж бүсийн наадам болсон билээ. Дундговь нутгийн ард түмэн Зава Дамдингийн даншүг наадам гэж нэрлэцгээж байв. Энэхүү Зава Дамдингийн даншүг наадмын их насны уралдаанд 3 даншүгийг түрүү магнай Гомбо-Очирын саарал морь түрүүлж байв. Хөдөөгийн малчин ардууд Зава Дамдингийн даншүг наадмыг дурсан санагалзаж их ярьцгаадаг юм.

#### **13. Зава Дамдингийн мэндлэсний 140 жилийн ой:**

Монголын гүн ухаантан, нэрт түүхч Зава Дамдингийн түмэн өлзий гийсний 140 жилийн ойг тэмдэглэх шийдвэрийг саяхан Дундговь аймгийн ИТХ гаргажээ. Цаг хугацаа гэгч амархан өнгөрдөг юм байна. Саяхан 130 жилийн ойг тэмдэглэх гэж бид хэрхэн ажиллаж байснаа дурсан санаж, энэ 2007 онд их эрдэмтнийхээ ойд ямар нэг хэмжээгээр оролцох юмсан гэж бодож байгаа нь энэ. Мөхөс миний бодлоор, их эрдэмтэн ламын ойг зохиол бүтээлийг нь сурталчилсан, эрдэм шинжилгээний хурал хийж номын баяр болгон тэмдэглэх нь зүйтэй юм шиг санагдана. 130 жилийн ойг БСШУЯ-ны сайдын тогтоол гарч, Дундговь аймгийн хэмжээнд тэмдэглэсэн. Энэ удаагийн 140 жилийн ойг ном эрдмийн талыг голлон Монгол улсын анхны академич байсны хувьд Шинжлэх Ухааны Академи анхааран дэмжиж, Улаанбаатар хотод ирэх 7 сард эрдэм шинжилгээний хурал хийлгэж олон эрдэмтдийг оролцуулах буй за. Гандантэгчэнлин хийдийн дэргэдэх Өндөр Гэгээн Занабазарын Нэрэмжит Монголын Бурханы Шашны Их Сургуулийн багш, лам хуврагууд зүй ёсоор оролцоно. Зава Дамдингийн талаар судалгаа хийсэн олон эрдэмтдийн зохиол бүтээлийг нэгтгэсэн “Зава Дамдин” гэсэн ном гаргаж нийтийн хүртээл болгон, номын баяр хийх саналтай байна. Ирээдүйд их эрдэмтний мэндлэсний 250 жилийн ойг тэмдэглэх үед Дэлхий анхаарч олон улсын байгууллага ЮНЕСКО-гоор тэмдэглүүлэхийн ерөөлийг талбин залбиръя.